

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2025
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/266/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 51-261885 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn Аудитор:Г. Сампилмаа Утас:51-263533 Цахим хаяг: sampilmaag@audit.gov.mn Ашид баланс Аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг Утас:99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1	Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2	Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4	Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
4.	АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1	Ерөнхий зүйл	16
4.2	Материаллаг байдал	16
4.3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1	Завсрын аудитын талаар	17
4.6	Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5.	АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1	Төлбөрийн акт.....	18
5.2	Албан шаардлага	18
5.3	Зөвлөмж.....	19
6.	АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.04 № 06/511
танай _____-ны № _____-т

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ
Т.БАТНАСАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Орон нутагт томилолтоор ажилласан ажилчдын томилолтын тооцоог тухай бүр хийдэггүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээр 2,022.4 мянган төгрөгийн тээврийн зардал баримтаар нотлогдохгүй;
- Чойбалсан групп ХХК-тай байгуулсан гэрээний үлдэгдэл 33,321.8 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй;
- Автомашины дулаан зогсоол ашиглах 02 дугаартай гэрээг 2 сарын хугацаатай, сарын 600.0 мянган төгрөг байхаар иргэнтэй 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан боловч 4 сарын төлбөрийг шууд зардлаар бүртгэж 1,230.0 мянган төгрөгийг илүү төлж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан нийт 36,574.2 мянган төгрөг байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41

дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус бүсийн захиргаанд 200 га тариалангийн талбай, махны чиглэлийн 100 үхрийн 950 м.кв байр, сүүний чиглэлийн 25 үхрийн 525 м.кв байр, өвс хадгалах 190 м.кв агуулах, авто граж, оффисын зориулалттай барилга, гүний худаг, газар тариалан, хадлан тэжээлийн зориулалттай нийт 20 төрлийн 24 техник хэрэгсэл, zimmatic брэндийн 200 га талбайг услах хүчин чадалтай 3 ширхэг усалгааны систем бүхий нийт 1,416.5 сая төгрөгийн хөрөнгө нь ашиглагдахгүй элэгдэж хуучирсан байдалтай байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2025 оны “Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай” 166 дугаар тогтоолын хавсралтад заасан хилийн зааг, эргэлийн цэгийн солбицол бүхийДорнод аймгийн Халх гол сумын нутаг дэвсгэр дэх 30,000 га...нийт 71,235.02 га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, “Атар 4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх, тариалангийн газрыг зориулалтын дагуу ашиглах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох эрх бүхий байгууллагын дарга нарт үүрэг болгосон байна. Тогтоолын хүрээнд бүсийн эзэмшлийн 30,000 мян.га талбайд тариалангийн талбайн хяналтын хэмжилт, дүгнэлтийг гаргуулан ажилласан байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Хөдөө аж ахуйн Халхгол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр 2 зорилт 8 арга хэмжээний гүйцэтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Дотоод аудитын газраас 83,8 хувьтай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	128,490,092.50	123,253,595.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		-
33	АВЛАГА	88,619,742.50	120,431,750.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,509,742.50	-
33500	Бусад авлага	87,110,000.00	120,431,750.00
33510	Байгууллагаас авах авлага		33,321,750.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	87,110,000.00	87,110,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	39,870,350.00	2,821,845.00
35100	Түүхий эд материал		
35110	Тусгай зориулалттай материал	800,000.00	800,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
35400	Хангамжийн материал	2,900,350.00	2,021,845.00
35410	Бичиг хэргийн материал	33,000.00	22,000.00
35420	Аж ахуйн материал	2,022,550.00	1,902,550.00
35440	Түлш шатах тослох материал	748,800.00	1,295.00
35470	Бусад хангамжийн материал	96,000.00	96,000.00
35600	Мал амьтад	36,170,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,505,706,152.95	1,416,502,051.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,505,706,152.95	1,416,502,051.97
39200	Биет хөрөнгө	1,429,896,150.67	1,344,682,047.41
39201	Барилга, байгууламж	2,431,853,114.00	1,281,191,310.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,542,327,370.31)	(483,089,046.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	218,397,424.10	352,857,749.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,685,810.29)	(110,025,804.73)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	520,819,717.85	1,487,470,161.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,175,694.85)	(1,188,891,253.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,416,480.12	21,771,880.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,493,709.95)	(16,602,948.47)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,184,000.00	2,184,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,092,000.00)	(2,184,000.00)
39300	Биет бус хөрөнгө	75,810,002.28	71,820,004.56
39301	Программ хангамж	2,600,000.00	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,600,000.00)	(2,600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	79,800,000.00	79,800,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,989,997.72)	(7,979,995.44)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,634,196,245.45	1,539,755,646.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,948,723.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		9,948,723.63
41300	Өглөг		9,948,723.63
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		9,948,723.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		
51	Засгийн газрын хувь оролцоо	1,634,196,245.45	1,529,806,923.34
51100	Засгийн газрын оруулсан капитал		
51200	Хуримтлагдсан үр дүн	1,634,196,245.45	1,529,806,923.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,281,924,241.91	1,779,611,469.20
51220	Тайлант үеийн үр дүн	(647,727,996.46)	(249,804,545.86)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,634,196,245.45	1,539,755,646.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,011,083,221.90	624,691,196.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	296,367,521.90	105,935,796.86
120	Нийтлэг татварын бус орлого	296,367,521.90	105,935,796.86
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	289,417,521.90	48,903,296.86
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	500,000.00	
120004	Бараа, үйлчилгээний орлого	1,100,000.00	47,602,500.00
1200042	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	5,350,000.00	9,430,000.00
122	Тусламжийн орлого		518,755,400.00
12211	Харьяа төрийн сангийн төсвийн байгууллагад олгосон санхүүжилт		518,755,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		518,755,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,715,700.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	713,615,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	713,615,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,100,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,100,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,014,591,062.61	872,986,000.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,699,695.17	780,372,258.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,273,958.10	356,460,556.60
210101	Үндсэн цалин	259,028,161.10	190,818,300.60
210102	Нэмэгдэл	108,404,797.00	111,239,256.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,610,000.00	37,681,000.00
210104	Урамшуулал	24,231,000.00	16,722,000.00
2102	Нийгмийн хамгааллын шимтгэл	54,904,736.14	43,748,983.63
210201	Тэтгэврийн даатгал	38,697,354.27	30,318,859.25
210202	Тэтгэмжийн даатгал	4,598,642.96	3,700,770.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,805,261.72	2,554,797.11
210204	Ажилгүйдлийн даатгал	1,757,167.89	1,434,911.39
210205	Эрүүл мэндийн даатгал	7,046,309.30	5,739,645.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,617,573.95	3,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,032,683.95	-
210302	Түлш, халаалт	873,370.00	-
210303	Цэвэр, бохир ус	171,020.00	-
210304	Байрны түрээс	1,540,500.00	3,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,288,400.00	9,874,066.73
210401	Бичиг хэрэг	1,009,200.00	634,300.00
210402	Тээвэр, шатахуун	11,658,900.00	6,599,540.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	846,100.00	540,226.43
210405	Хон хаягдал		550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,874,200.00	1,020,000.00
210408	Бараа материал акталсны зардал	20,900,000.00	530,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,886,600.00	630,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		480,000.00
210604	Урсгал засвар	10,886,600.00	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,836,800.00	9,362,400.00
210702	Дотоод албан томилолт	10,836,800.00	9,362,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,495,460.00	28,093,630.00

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,037,860.00	22,433,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,220,000.00	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,396,166.98	328,962,621.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,719,000.00	45,070,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	260,677,166.98	283,522,621.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,891,367.44	92,613,741.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,431,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,431,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,360,367.44	92,613,741.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,360,367.44	92,613,741.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,100,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(3,507,840.71)	(248,294,803.36)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	644,220,155.75	
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	247,515,277.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		(1,509,742.50)
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	396,704,878.75	-
5	НИЙТ ҮР ДҮН	(647,727,996.46)	(249,804,545.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	715,815,700.00	533,036,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,100,000.00	14,280,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,100,000.00	14,280,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,100,000.00	14,280,750.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,100,000.00	14,280,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,715,700.00	518,755,400.00
122	Тусламжийн орлого		518,755,400.00
1221	Хандив тусламж /дотоод/		518,755,400.00
12211	Улсын төвлөрсөн төсвөөс	713,615,700.00	518,755,400.00
122111	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	713,615,700.00	518,755,400.00
12	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,100,000.00	
120004	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,100,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	715,815,700.00	533,036,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	715,815,700.00	533,036,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,924,332.56	440,422,408.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,433,398.05	352,962,063.29
210101	Үндсэн цалин	253,212,348.64	190,538,162.06
210102	Нэмэгдэл	108,429,049.41	109,680,242.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,561,000.00	37,681,000.00
210104	Урамшуулал	24,231,000.00	15,062,659.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,888,300.56	47,247,476.94
210201	Тэтгэврийн даатгал	38,666,985.21	34,386,111.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,540,642.52	2,857,581.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,577,663.00	1,698,854.21
210204	Ажилгүйдлийн даатгал	2,053,505.24	1,960,264.82
210205	Эрүүл мэндийн даатгал	7,049,504.59	6,344,664.84

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,617,573.95	3,240,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,032,683.95	-
210302	Түлш, халаалт	873,370.00	-
210303	Цэвэр, бохир ус	171,020.00	-
210304	Байрны түрээс	1,540,500.00	3,240,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,386,200.00	8,381,238.10
210401	Бичиг хэрэг	1,009,200.00	620,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,407,700.00	5,852,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	846,100.00	459,238.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,123,200.00	1,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,266,600.00	630,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	784,800.00	-
210604	Урсгал засвар	10,481,800.00	630,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,836,800.00	4,498,000.00
210702	Дотоод албан томилолт	10,836,800.00	4,498,000.00
210701	Гадаад албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,495,460.00	23,093,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,037,860.00	22,433,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,600.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,220,000.00	660,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		370,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		370,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,891,367.44	92,613,741.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,431,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,431,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,360,367.44	92,613,741.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,360,367.44	92,613,741.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,100,000.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,100,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	715,815,700.00	533,036,150.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			2,281,924,241.91	2,281,924,241.91
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			2,281,924,241.91	2,281,924,241.91
Тайлант үеийн үр дүн			(647,727,996.46)	(647,727,996.46)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			1,634,196,245.45	1,634,196,245.45
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			145,415,223.75	145,415,223.75
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			1,779,611,469.20	1,779,611,469.20
Тайлант үеийн үр дүн			(249,804,545.86)	(249,804,545.86)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			1,529,806,923.34	1,529,806,923.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	717,591,700.00	533,036,150.00	184,555,550.00	74.3
12	Татварын бус орлого	45,900,000.00	36,714,450.00	9,185,550.00	80.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого / үндсэн/	45,900,000.00	36,714,450.00	9,185,550.00	80.0
122	Тусламжийн орлого	671,691,700.00	496,321,700.00	175,370,000.00	73.8
122005	Төсвөөс санхүүжих	671,691,700.00	496,321,700.00	175,370,000.00	73.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	717,591,700.00	533,036,150.00	184,555,550.00	74.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,591,700.00	533,036,150.00	184,555,550.00	74.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,591,700.00	440,422,408.33	277,576,491.67	61.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	546,759,900.00	352,962,063.29	193,797,836.71	64.6
210101	Үндсэн цалин	304,276,500.00	190,538,162.06	113,738,337.94	62.6
210102	Нэмэгдэл	151,617,700.00	109,680,242.00	41,937,458.00	72.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	42,857,000.00	37,681,000.00	5,176,000.00	87.9
210104	Урамшуулал	48,008,700.00	15,062,659.23	32,946,040.77	31.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,681,400.00	47,247,476.94	22,433,923.06	67.8
210201	Тэтгэврийн даатгал	47,586,500.00	34,386,111.16	13,200,388.84	72.3
210202	Тэтгэмжийн даатгал	5,515,500.00	2,857,581.91	2,657,918.09	51.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,762,300.00	1,698,854.21	1,063,445.79	61.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,777,400.00	1,960,264.82	817,135.18	70.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,039,700.00	6,344,664.84	4,695,035.16	57.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,089,300.00	3,240,000.00	1,849,300.00	63.7
210301	Гэрэл, цахилгаан	826,400.00		826,400.00	
210302	Түлш, халаалт	779,300.00		779,300.00	
210303	Цэвэр, бохир ус	243,600.00		243,600.00	
210304	Байрны түрээс	3,240,000.00	3,240,000.00	0.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	16,403,400.00	8,381,238.10	8,022,161.90	51.0

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

210401	Бичиг хэрэг	750,000.00	620,000.00	130,000.00	82.7
210402	Тээвэр, шатахуун	11,400,000.00	5,852,000.00	5,548,000.00	51.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	459,238.10	1,340,761.90	25.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,453,400.00	1,450,000.00	1,003,400.00	59.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,212,700.00	630,000.00	1,582,700.00	28.5
210604	Урсгал засвар	1,820,300.00	630,000.00	1,190,300.00	34.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	392,400.00		392,400.00	
2107	Дотоод албан томилолт	7,545,700.00	4,498,000.00	3,047,700.00	59.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,500,100.00	23,093,630.00	44,406,470.00	34.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,021,900.00	22,433,630.00	33,589,270.00	40.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,818,300.00		1,818,300.00	
210803	Даатгалын үйлчилгээ	490,900.00		490,900.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,801,500.00		1,801,500.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	167,500.00		167,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,200,000.00	660,000.00	6,540,000.00	9.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,998,200.00	370,000.00	2,628,200.00	12.4
210902	Хичээл үйлдвэрлэл	370,000.00	370,000.00	-	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
213206	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,628,200.00	-	2,628,200.00	
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		92,613,671.67	(92,613,741.67)	
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
	Төсвийн байгууллага				
	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	10	12	52.5
	Удирдах ажилтан	1	1	-	
	Гүйцэтгэх ажилтан	18	7	12	66.7
	Үйлчлэх ажилтан	2	2	-	
	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	10	12	52.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөө аж ахуйн “Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь Дорнод аймгийн Халх гол сум дахь улсын тусгай хэрэгцээний газарт эрчимжсэн мал аж, ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрөөс хөдөө аж ахуйн газар тариалангийн бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгон зах зээлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн болон газар тариалангийн үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Бүсийн захиргааны дүрэмд байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Эрчимжсэн мал аж ахуйг нэвтрүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өртгийн сүлжээ бий болгох, зохистой дадлыг нэвтрүүлэх, мал аж ахуйн аялал жуулчлал, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, үйлдвэрлэл технологийн агро парк байгуулах;
2. Олон улсын болон дотоодын мал аж ахуй, газар тариалангийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт болон үйлдвэрлэлийн технологийн үр дүнд суурилсан санал санаачилгыг төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах хэрэгжүүлэх;
3. Зорилтот хэрэглэгчидтэй экспорт, импортын худалдааны гэрээ хийх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч болон хүнсний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдэд худалдааны зуучлал хийх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;
4. Хөрш болон олон улсын зах зээлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний брэндийг бий болгох;
5. Халх гол бүс нутагт экспортын баримжаатай үйлдвэрлэл хөгжүүлэх;
6. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2025 оны “Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай” 166 дугаар тогтоол, Атар-IV тариалангийн тогтвортой аяныг өрнүүлэх тухай 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, “Мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрт эрүүл бүс байгуулах тухай” 2022 оны 424 дугаар тогтоол, бусад холбогдох эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлийг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Байгууллагын бүтэц орон тоонд дотоод хяналтын нэгж, ажилтан байхгүй байна.

Тайлант онд ХХААХҮЯ-аас дотоод хяналт хэрэгжүүлээгүй тул дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/359 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байгаа боловч холбогдох хууль тогтоомж, журмын шинэчлэл өөрчлөлтийг бодлогын баримт бичигт тухай бүр тусгаагүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 94,440.6 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	88,619.7	120,431.8	31,812.1
Бараа материал	39,870.4	2,821.8	(37,048.6)
Үндсэн хөрөнгө	1,505,706.2	1,416,502.0	(89,204.2)
Нийт хөрөнгө	1,634,196.2	1,539,755.6	(94,440.6)
Өр төлбөр	-	9,948.7	9,948.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,634,196.2	1,529,806.9	(104,389.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,634,196.2	1,539,755.6	(94,440.6)

- Авлага дансны үлдэгдэл 31,812.1 мянган төгрөгөөр өссөн нь Хөдөө аж ахуйн бирж, Чойбалсан групп ХХК-тай байгуулсан гурвалсан гэрээний дагуу 55 толгой үхрийг худалдан борлуулсан авлагын үлдэгдэл 33,321.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, ажиллагсадтай холбоотой 1,509.7 мянган төгрөгийн авлагаар буурсантай холбоотой;
- Бараа материалын үлдэгдэл 2,821.6 мянган төгрөг болж, 37,048.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд малын нас дэвшилт, зах зээлийн үнийн өөрчлөлтийн орлого 9,430.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 55 толгой мал худалдан борлуулсан 45,600.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 878.6 мянган төгрөгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 89,204.2 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 809 дүгээр тогтоолыг үндэслэн элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 10 нэрийн, нийт 100,487.4 мянган төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данснаас хасаж, цаашид ашиглаж болох 10 нэрийн хөрөнгийг нийт 41,162.6 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн нь нөлөөлжээ;
- Өр төлбөрийн үлдэгдэл 9,948.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсад өгөх өглөг 4,948.7 мянган төгрөг, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын гэрээт ажлын хөлсний төлбөр 5,000.0 мянган төгрөгийн өр төлбөр үлдэгдэл нөлөөлсөн байна.

Тус бүсийн биет бус хөрөнгийн дансанд 2,600.0 мянган төгрөгийн өртөгтэй Хас эрин орчил ХХК-ийн vet.dynamic.mn онлайн санхүүгийн программ бүртгэлтэй, тайлант онд программын үйлчилгээний төлбөр 660.0 мянган төгрөг төлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус бүсийн захиргаа 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 723,316.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 13,800.0 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт зарлагыг 737,116.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 19,923.3 мянган төгрөгөөр бууруулж, 717,591.7 мянган төгрөгөөр баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 426,141.6 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 14,280.8 мянган төгрөг, нийт 440,422.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, цалингийн зардал 352,962.1 мянган төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 47,247.5 мянган төгрөг, тогтмол зардал 3,240.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 8,381.2 мянган төгрөг, урсгал зардалд 630.0 мянган төгрөг, томилолтын зардал 4,498.0 мянган төгрөг, бараа үйлчилгээ 370.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 23,093.6 мянган төгрөг, нийт 440,422.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 440,422.4 мянган төгрөг буюу 74.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 140,902.9 мянган төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 9,066.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, ажил олгогчийн тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 600.0 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрлэлийн бодлого удирдлага	717,591.8	440,422.4	(277,169.2)	61.4
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	685,491.7	417,988.8	(267,502.9)	60.9
2	80802 Ажил олгогчийн тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	600.0	0	600.0	0
3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал	31,500.0	22,433.7	(9,066.3)	71.2

Бүсийн захиргааны захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар албан тушаалын зэрэглэл, 21 албан хаагч, ажилтантай байхаар орон тоог баталсан. Гүйцэтгэлээр удирдлага 1, гүйцэтгэх ажилтан 7, үйлчилгээний ажилтан 2 нийт 10 албан хаагч, ажилтан ажиллаж байна.

Бүсийн захиргааны захирлын 2025 оны А/04 дүгээр тушаалаар цалингийн шатлал, төрийн албаны нэмэгдэл, нэг ажилтанд ногдох өдрийн хоол 32.0 мянган төгрөг, унаа 3.0 мянган төгрөг олгохоор баталсан байна. Тайлант онд хоол, унааны хөнгөлөлтөд нийт 37,681.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд гадаад томиллолт, семинарын зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээ зардал гараагүй, төрд учирсан хохирлын төлбөрийн асуудал байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлаагүй. Засгийн газрын 2025 оны “Атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх тухай” 166 дугаар тогтоолоор баталсан Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн эзэмшлийн 30.0 мянган га талбайд тариалангийн талбайн хэмжилт хийх гэрээт ажил 13,000.0 мянган төгрөг, улсын тусгай хэрэгцээний газарт төлөвлөлтийн зураг дэлгэрэнгүй хийж гүйцэтгэхэд 4,470.0 мянган төгрөг, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Дорнод аймгийн Халх гол суманд байрлах малчны өвөлжөөний өтөг бууц түрж, тэгшлэх ажилд 4,500.0 мянган төгрөг нийт 21,970.0 мянган төгрөгийн ажил, үйлчилгээнд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах НБББББ-т стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган шинэчлэх, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох, санхүүгийн программ нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Ашид баланс Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Д.Алтанцэцэг, аудитор Т.Баясгалан, туслах аудитор Б.Доржсүрэн нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Оюунчимэг, захирал Л.Майцэцэг анхан шатны хяналтыг, Санхүүгийн аудитын газрын гэрээт аудитор Г.Сампилмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ашид баланс Аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийлсэн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,014,591.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,145.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага ямар нэгэн тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Тайлант оны батлагдсан төсөв 717,591.7 мянган төгрөг, нийт зардал 440,422.5 мянган төгрөгийг зарцуулж 277,169.2 мянган төгрөгийн зардлын санхүүжилтийн эрх нээгээгүйгээс дутуу зарцуулсан байна. Аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой 31 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэхэд зөрчил, дутагдал илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 544,818.4 мянган төгрөгийн 10 мэдээлэл, зарлагын 196,047.0 мянган төгрөгийн 3 мэдээлэл, байгууллагын батлагдсан төсөв 717,220.0 мянган төгрөг, нийт 1,458,085.4 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй, Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн..

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө, бараа материал, нийгмийн даатгалын өглөгийн данстууд болон өмнөх зөвлөмж, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулан, асуудлын бүртгэлээр баталгаажуулж 1,335,024.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 11,762.1 мянган төгрөгийг төсөв төвлөрүүлэхээр 2 төлбөрийн акт, 114,618.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 14,782.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	11,762.1	2	11,762.1	100
Албан шаардлага	4	114,618.9	4	114,618.9	100
Зөвлөмж	2	14,782.5	2	14,782.5	100
Нийт дүн	8	141,163.5	8	141,163.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу Засгийн газрын finperform.mof.gov.mn санхүүгийн программаар 2025 оны санхүүгийн тайлан бэлтгэхэд программын шинэчлэлт жигдрээгүй, тайлан баталгаажуулахад хүндрэлтэй байлаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын гэрээт ажлын төлбөр 5,000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлагналын “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 134,220.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1,230.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 35,344.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 97,646.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 134,220.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 122,844.3 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Автомашины дулаан зогсоол ашиглах 02 дугаартай гэрээг 2 сарын хугацаатай, сарын 600.0 мянган төгрөг байхаар иргэнтэй 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан боловч 4 сарын төлбөрийг шууд зардлаар бүртгэж 1,230.0 мянган төгрөгийг илүү төлж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү төлсөн түрээсийн төлбөрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх.

5.2 Албан шаардлага

1. Орон нутагт томилолтоор ажилласан ажилчдын томилолтын тооцоог тухай бүр хийдэггүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээр 2,022.4 мянган төгрөгийн тээврийн зардал анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын тооцоог тухай бүр хийгээгүй, нотлох баримтын бүрдэлгүй тээврийн зардлыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох.

2. Чойбалсан групп ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл 33,321.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлагыг барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоох.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2019 онд батлагдсан НББББ-г шинэчлэн боловсруулаагүй нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хуулийн заалт, журам аргачлал нь хүчингүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт стандарт болон хуулийн өөрчлөлтийг тусган, төсвөөс зардал гаргахгүйгээр өөрсдийн нөөц бололцоогоор шинэчлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Барилга байгууламж, тээврийн хэрэгслийн нийт 27 нэр төрлийн 29 үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 97,646.0 мянган төгрөгөөр илүү тооцож зардал өсгөсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт тусгасан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох арга, ашиглах жилийн хугацааг санхүүгийн программд оруулж шинэчлэлт хийлгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын ажлын гэрээний төлбөрийг бүртгээгүй.	1	5,000.0					1	5,000.0				
	Дүн	1	5,000.0					1	5,000.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Орон нутагт томилолтоор ажилласан ажилчдын томилолтын тооцоог тухай бүр хийдэггүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээр 2,022.4 мянган төгрөгийн тээврийн зардал баримтаар нотлогдохгүй байна.	1	2,022.4			1	2,022.4						
2	Авто машины дулаан зогсоол ашиглах 02 дугаартай гэрээг 2 сарын хугацаатай сарын 600.0 мянган төгрөг байхаар иргэнтэй 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан боловч 4 сарын төлбөрийг шууд зардлаар бүртгэж 1,230.0 мянган төлбөрийг илүү төлж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.	1	1,230.0	1	1,230.0								

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

3	Чойбалсан групп ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл 33,321.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлага барагдаагүй, арга хэмжээ аваагүй байна.	1	33,321.8			1	33,321.8				
4	Барилга байгууламж, тээврийн хэрэгслийн нийт 27 нэр төрлийн 29 үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 97,646.0 мянган төгрөгөөр илүү тооцож зардал өсгөсөн	1	97,646.0					1	97,646.0		
5	2019 онд батлагдсан НББББ-г шинэчлэн боловсруулаагүй нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хуулийн заалт, журам аргачлал нь хүчингүй болсон байна.	1						1			
Дүн		5	134,220.2	1	1,230.0	2	35,344.1	2	97,646.0		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үгийн дүн бүхий орлогын 544,818.4 мянган төгрөгийн 10 мэдээлэл, зарлагын 196,047.0 мянган төгрөгийн 3 мэдээлэл, байгууллагын батлагдсан төсөв 717,220.0 мянган төгрөг, нийт 1,458,085.4 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна.	1	1,458,085.4	1	1,458,085.4		
	Дүн	1	1,458,085.4	1	1,458,085.4		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 171/АО150079

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутагт томилолтоор ажилласан ажилчдын томилолтын тооцоог тухай бүр хийдэггүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснээр 2,022,400.00 /хоёр сая хорин хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн тээврийн зардал баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:** Томилолтын тооцоог тухай бүр хийгээгүй, нотлох баримтын бүрдэлгүй тээврийн зардлыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;

1. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал /Т.Энхнасан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Энхбилэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Л.МАЙЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 27/АД150079

Улаанбаатар хот

САГ - 2026/266/НА - СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автомашин дулаан зогсоол ашиглах 02 дугаартай гэрээг 2 сарын хугацаатай, сарын 600,000.00 /зургаан зуун мянган/ төгрөг байхаар иргэнтэй 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан боловч 4 сарын төлбөрийг шууд зардлаар бүртгэж 1,230,000.00 /нэг сая хоёр зуун гучин мянган/ төгрөгийг илүү төлж төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5 "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү төлсөн түрээсийн төлбөр 1,230,000.00 (нэг сая хоёр зуун гучин мянган) төгрөгийг ерөнхий нягтлан бодогч /Н.Энхбилэг/-оор төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дах Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал /Т.Эхнасан/-д даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР


Э. Энхбаатар

Э.ЭНХБААТАР

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Л. Майцэцэг

Л.МАЙЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 169/АД150079

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чойбалсан групп ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэл 33,321,750.00 /гучин гурван сая гурван зуун хорин нэгэн мянган долоон зуун тавин/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг барагдаагүй арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн зүйлийн 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, авлагыг барагдуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал /Т.Энхнасан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Энхбилэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Т-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-28.Docx

1526180535



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 170/А0150079

Улаанбаатар хот

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 544,818,400,00 /таван зуун дөчин дөрвөн сая найман зуун арван найман мянга дөрвөн зуун/ төгрөгийн 10 мэдээлэл, зарлагын 196,047,000.00 /нэг зуун ерөн зургаан сая дөчин мянга долоон зуун/ төгрөгийн 3 мэдээлэл, байгууллагын батлагдсан төсөв 717,220,000.00 /долоон зуун арван долоон сая хоёр зуун хорин мянган/ төгрөг, нийт 1,458,085,400.00 /нэг тэрбум дөрвөн зуун тавин найман сая наян таван мянга дөрвөн зуун/ төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст мэдээлэх мэдээллийг тухай бүр тогтмол мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал /Т.Энхнасан/, Ерөнхий нягтлан бодогч /Н.Энхбилэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.Наранчимэг
Э.Энхбаатар

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР

Л.МАЙЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-28.Docx

1526180537